



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн
багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/22/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
odgerell@audit.gov.mn

Шинжээч: Б.Энхжин
Утас: 261628
Цахим хаяг:
enkhjinb@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

АГУУЛГА

АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй,
хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон
нарийвчилсан горим, түүний үр дүн
Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл,
тайлбар
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний
талаарх тайлбар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой
бол) тайлбар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын
тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн
зөрчлийн нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх
дүгнэлт

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Аудит хийсэн санхүүгийн тайлан
Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-САГ/2015/22/СТА-ТЕЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 17-ноос 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын орон нутгийн аудитын албаны шинжээч Б.Энхжин хэрэгжүүлэв.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 2015 оны 3 дугаар сарын 10-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 17-ноос 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуульд заасан цаглабарын хугацаанд Сонгуулийн ерөнхий хорооны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Сонгуулийн ерөнхий хороо нь дараа хууль тогтоомжуудын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль

- Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг улсын хэмжээгээр эрхлэн зохион байгуулах чиг үүрэгтэй, үйл ажиллагаагаа бие дааж, хамтын удирдлагын зарчмаар явуулдаг байнгын ажиллагаатай төрийн байгууллага юм.

Анх Улсын Бага Хурлын 1992 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор тус Хороог 15 гишүүнтэй байгуулсан байна. Сонгуулийн ерөнхий хороог Монгол Улсын Их Хурлаас дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр 6 жилийн хугацаагаар томилон ажиллуулдаг.

Их Хурлын сонгуулийг 5 удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийг 4 удаа эрхлэн зохион байгуулж, дүнг нэгтгэн Улсын Их Хуралд тайлагнаж, Орон нутгийн Хурлын 4 удаагийн сонгуулийг бэлтгэн явуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан байна.

Хорооны Ажлын алба нь захиргааны тасаг, бодлого зохицуулалтын тасаг, сургалт, судалгааны тасаг гэсэн бүтцэд хуваагдан сонгуулийн зохион байгуулалт, орон нутаг, хууль тогтоомж, хяналт шалгалт, мэдээлэл сурталчилгаа, судалгаа сургалт, гадаад харилцаа, дотоод ажлын зохион байгуулалт хариуцсан ажилтан, даргын туслах, бичиг хэрэг, архивын эрхлэгч гэсэн ажилтнуудтай ажиллаж тус бүрийн ажлын чиг үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад СЕХ нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлан мөрдөж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

СЕХ-ны үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

СЕХ-ны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Acolous 3.0” програмаар, салбарын нэгдгэсэн тайланг “Plastic” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгов. Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 762.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь буюу 15.2 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Дотоод хяналт

СЕХ-ны дотоод хяналтыг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын тогтолцоог хэвийн гэж үзэв.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь 2014 онд урсгал төсөв 770.9 сая, хөрөнгө оруулалтын төсөв 30.0 сая, нийт 800.9 сая төгрөг батлагдсан бөгөөд үүнээс урсгал зардалд 744.5 сая, хөрөнгө оруулалтын зардалд 28.9 сая, нийт 761.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 12.3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны төсвийн гүйцэтгэл 95 хувийн зарцуулалттай гарч байгаа бөгөөд зардлыг зүйл ангиар зарцуулалт, гүйцэтгэлийн хувь дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал – 383.0 сая төгрөг буюу 94,4%
- НДШ – 42.2 сая төгрөг буюу 94,6%
- Бараа үйлчилгээний зардал – 152.5 сая төгрөг буюу 96,7%
- Татаас ба урсгал шилжүүлэг – 154.5 сая төгрөг буюу 94,8%

Төсвийн гүйцэтгэлээс харахад цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 22.5 сая, дотоод томилолт 3.2 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 8.4 сая зэрэг зардлууд хэмнэлттэй гарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- *Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал:* Тайлант хугацаанд 2 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байснаас цалин, НДШ-ийн зардал хэмнэгдэж үлдсэн.

- *Дотоод томилолт:* Сарын хуваарьт өөрчлөлт оруулахдаа дотоод томилолтын зардлын санхүүжилтийг оны эцэст тавьсан хуваарилсан боловч зардлын гүйлгээ хийх эрхийг нээж өгөөгүйгээс хэмнэгдсэн.
- *Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал:* Уг зардлын 10-12 дугаар сарын гүйлгээ хийх эрхийг дутуу нээж өгснөөс хэмнэлт үүссэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 40 дүгээр захирамжаар Хорооны шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт тавих Ажлын хэсгийг Хорооны нарийн бичгийн даргаар ахлуулах байгуулж, мөн хуулийг хэрэгжүүлэх 30 заалт бүхий ажлын төлөвлөгөөг баталсан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны www.ges.gov.mn цахим хуудсанд “Шилэн данс” булан нээж түүн дотроо Сонгуулийн Ерөнхий Хороо, Ажлын алба, Мэдээллийн технологийн төв гэсэн цэсийг тус бүр 5 ерөнхий ангиллаар нээж холбогдох мэдээллийг байршуулж байна.

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар 9 төрлийн 19 мэдээллийг Шилэн данс нэгдсэн цахим хуудас болон Хорооны цахим хуудсанд байршуулсан байна. Мөн мэдээллийн самбарт дээрх мэдээллийг баталгаажуулан байршуулж ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлүүдийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрт нарийвчилсан горим, сорил 12-г гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

СЕХ-ны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг бус хэмжээний дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сонгуулийн ерөнхий хороо нь 2014 оны жилийн эцсийн үр дүнгийн урамшуулалыг 57-29 хувиар тооцож, нийт 8.2 сая төгрөгийг олгосон нь “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-д заасан хувь хэмжээ буюу 40 хувиар тооцвол 1.6 сая төгрөгийг илүү олгосон байна.
Энэ нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-ын 5-д зааснаар “...улиралын ажлын үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно..” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-ыг баримтлан ажиллах зөвлөмж өгөв.

2. Тухайн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Үндсэн хөрөнгийн элэгдлийг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ыг баримтална гэж заасан байна. Гэтэл энэхүү тогтоолыг 2014 оны 9 дүгээр сарын 14-ний Засгийн газрын 297 дугаар тогтоолоор хүчингүй болсон боловч НББ-ын бичиг баримтад өөрчлөлт оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдлийг НББОУС-д заасны дагуу өөрчлөлт оруулах зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Залруулагдах боломжгүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2013 оны жилийн эцсийн аудитаар нийт 3 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хариуг 2014 оны 7 дугаар сарын 7-ны өдөр ҮАГ-т хүргүүлсэн бөгөөд зөвлөмж бүрэн биелэгдсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалын талаар

Асуудал 2

НББ-н бодлогын баримт бичгийн талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Сонгуулийн ерөнхий хорооны даргад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Сонгуулийн ерөнхий хороо нь 2014 оны жилийн эцсийн үр дүнгийн урамшуулалыг 57-29 хувиар тооцож, нийт 8.2 сая төгрөгийг олгосон нь “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-д заасан хувь хэмжээ буюу 40 хувиар тооцвол 1.6 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-ын 5-д зааснаар “...улиралын ажлын үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”-ыг баримтлан ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 08 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Батлагдсан төсөв хэтрүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: НББ-бодлогын баримт бичиг	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тухайн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Үндсэн хөрөнгийн элэгдлийг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам”-ыг баримтална гэж заасан байна. Гэтэл энэхүү тогтоолыг 2014 оны 9 дүгээр сарын 14-ний Засгийн газрын 297 дугаар тогтоолоор хүчингүй болсон боловч НББ-ын бичиг баримтад өөрчлөлт оруулаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдлийг НББОУС-д заасны дагуу өөрчлөлт оруулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 08 дугаар сарын 1-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Үндсэн хөрөнгийн элэгдлийг илүү, дутуу тооцох;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ДАРГА
Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

2015.04.24 № 490
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3,679.50	4,500.30
Кассад байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
Жижиг мөнгөн сан	3,679.50	4,500.30
Төсөвт байгууллагын харилцахын үлдэгдэл	0.00	0.00
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.00	0.00
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
АВЛАГА	0.00	0.00
Бусад авлага	0.00	0.00
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	0.00	0.00
Урьдчилгаа тооцоо	0.00	0.00
Урьдчилж гарсан зардал	0.00	0.00
БАРАА МАТЕРИАЛ	154,613,333.22	142,850,895.72
Бичиг хэргийн материал	9,976,050.00	4,432,963.00
Аж ахуйн материал	132,537,217.22	129,631,775.72
Бусад	12,100,066.00	8,786,157.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	154,617,012.72	142,855,396.02
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
БУСАД ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,459,259,719.76	5,979,295,560.94
Биет хөрөнгө	7,650,641,120.56	4,690,782,345.89
Авто тээврийн хэрэгсэл	80,100,000.00	80,100,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-6,675,000.00	-20,025,000.00
Машин, тоног төхөөрөмж /компьютер/	11,870,833,815.88	11,883,784,115.88
Хуримтлагдсан элэгдэл	-4,471,461,145.23	-7,423,031,478.01
Тавилга, аж ахуйн эд хогшил	251,196,113.00	266,091,013.00
Хуримтлагдсан элэгдэл	-73,352,663.09	-96,136,304.98
Биет бус хөрөнгө	1,808,618,599.20	1,288,513,215.05
Программ хангамж	2,589,216,579.95	2,589,216,579.95
Хуримтлагдсан элэгдэл	-780,597,980.75	-1,300,703,364.90
Бусад	0.00	0.00
Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,459,259,719.76	5,979,295,560.94
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,613,876,732.48	6,122,150,956.96
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
Өглөг	0.00	0.00
Урьдчилж орсон орлого	0.00	0.00
Төсөвт байгууллага	0.00	0.00
Бусад урьдчилж орсон орлого		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо	9,613,876,732.48	6,122,150,956.96
ЗГ-ын оруулсан капитал	14,410,826,088.57	14,410,826,088.57
Хуримтлагдсан үр дүн	-4,798,886,445.85	-8,290,612,221.37
Өмнөх үеийн үр дүн	-1,576,911,258.19	-4,798,886,445.85
Тайлант үеийн үр дүн	-3,221,975,187.66	-3,491,725,775.52
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,937,089.76	1,937,089.76
Бодлогын өөрчлөлтийн алдааны залруулга	0.00	0.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	9,613,876,732.48	6,122,150,956.96
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	9,613,876,732.48	6,122,150,956.96

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН - ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,322,676,786.50	783,517,640.80
Улсын төсвөөс	12,322,676,786.50	783,466,820.00
Урсгал	12,184,138,132.00	744,558,580.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт	129,011,675.00	28,908,240.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	52,079.50	50,820.80
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,474,900.00	0.00
Төсвийн урамшуулал	0.00	10,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,322,676,786.50	783,517,640.80
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	355,962,886.95	425,234,668.67
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	320,851,186.06	383,040,282.42
Цалин	304,131,820.12	359,283,182.42
Унаа хоол	16,719,365.94	23,757,100.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	35,111,700.89	42,194,386.25
Тэтгэврийн даатгалын шимтгэл-7%	22,343,723.41	26,850,973.15
Тэтгэмжийн даатгалын шимтгэл-0.8%	2,553,568.38	3,068,682.62
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл-1%	3,192,096.03	3,835,853.28
Ажилгүйдлын даатгалын шимтгэл-0.2%	638,392.10	767,170.65
Эрүүл мэндийн даатгалын хураамж-2%	6,383,920.97	7,671,706.55
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	15,185,437,928.78	3,850,008,747.65
Бусад бараа үйлчилгээний зардал	15,179,520,548.78	3,695,261,547.65
Бичиг хэргийн материал	23,122,547.00	7,638,601.00
Тээвэр, шатахууны зардал	29,138,880.00	31,481,050.00
Шуудан холбооны зардал	16,334,562.44	16,362,434.01
Дотоод томилолтын зардал	12,860,735.00	5,058,783.80
Гадаад томилолтын зардал	50,547,495.00	57,874,325.00
Ном, хэвлэлийн зардал	6,923,276.00	3,508,400.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	129,074,004.50	4,915,869.50
Төлбөр, хураамж, жижиг татварууд зардал	2,870,444.00	6,007,522.00
Байрны түрээсийн зардал	44,123,070.00	40,790,560.00
Элэгдлийн зардал	3,484,886,471.23	3,507,809,358.82
Сонгуулийн зардал	11,181,298,733.60	0.00
Олон улсын байгууллагын гишүүний татвар	1,405,000.00	1,500,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	196,935,330.01	12,314,643.52
Ажил олгогчоос өрх гэрт олгох тэтгэмж	5,917,380.00	154,747,200.00
Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,250,000.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,667,380.00	154,747,200.00
Хөрөнгө оруулалт		0.00
Төсвийн хөрөнгө оруулалт /Тоног төхөөрөмж/		0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	15,541,400,815.73	4,275,243,416.32
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-3,218,724,029.23	-3,491,725,775.52
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	0.00	0.00
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	0.00	0.00
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)	0.00	0.00
Хөрөнгө худалдсаны гарз	3,251,158.43	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	3,251,158.43	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-3,221,975,187.66	-3,491,725,775.52

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,184,138,132.00	744,558,580.00
Улсын төсвөөс	12,184,138,132.00	744,558,580.00
Урсгал	12,184,138,132.00	744,558,580.00
НД-ын сангаас		7,761,238.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт	129,011,675.00	28,908,240.00
Орон нутгийн төсвөөс /Саналын хуудас/		
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	5,889,979.50	50,820.80
Төсвийн урамшуулал		10,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	12,319,039,786.50	791,278,878.80
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	12,190,024,432.00	762,369,818.00
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	355,962,886.95	425,234,668.67
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	320,851,186.06	383,040,282.42
Цалин	304,131,820.12	359,283,182.42
Унаа хоолны хөнгөлөлт	16,719,365.94	23,757,100.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	35,111,700.89	42,194,386.25
Тэтгэврийн даатгалын шимтгэл-7%	22,343,723.41	26,850,973.15
Тэтгэмжийн даатгалын шимтгэл-0.8%	2,553,568.38	3,068,682.62
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл-1%	3,192,096.03	3,835,853.28
Ажилгүйдлын даатгалын шимтгэл-0.2%	638,392.10	767,170.65
Эрүүл мэндийн даатгалын хураамж-2%	6,383,920.97	7,671,706.55
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	11,834,061,545.05	174,626,711.33
Бусад бараа үйлчилгээний зардал	11,828,144,165.05	174,626,711.33
Бичиг хэргийн зардал	4,104,075.00	2,123,799.00
Тээвэр, шатахууны зардал	29,138,880.00	31,481,050.00
Шуудан холбооны зардал	16,334,562.44	16,432,434.01
Дотоод томилолтын зардал	12,860,735.00	5,058,783.80
Гадаад томилолтын зардал	50,860,984.00	57,872,620.00
Ном, хэвлэлийн зардал	1,048,400.00	1,023,300.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	3,712,044.00	6,029,521.00
Байрны түрээсийн зардал	44,123,070.00	40,790,560.00
Сонгуулийн зардал	11,467,621,084.60	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	196,935,330.01	12,314,643.52
Олон улсын байгууллагын гишүүний татвар	1,405,000.00	1,500,000.00
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	5,917,380.00	162,508,438.00
Ажил олгогчоос өрх гэрт олгох тэтгэмж	5,917,380.00	154,747,200.00
Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,250,000.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,667,380.00	154,747,200.00
Тэтгэмжийн даатгалын сан		7,761,238.00
Жирэмсний, амаржсаны тэтгэмж		7,141,238.00
Оршуулгын тэтгэмж		620,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	12,190,024,432.00	762,369,818.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	129,015,354.50	28,909,060.80
Хөрөнгийн орлого	0.00	0.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
Бусад хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
Төсвийн хөрөнгө оруулалт /Тоног төхөөрөмж/	129,011,675.00	28,908,240.00
Урьд оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл	0.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	129,011,675.00	28,908,240.00

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(YI)=(IY)-(V)	-129,011,675.00	-28,908,240.00
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	3,679.50	820.80
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	3,679.50	820.80
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	3,679.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,679.50	4,500.30

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО
2012 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	14,410,826,088.57	1,937,089.76	-1,576,911,258.19	12,835,851,920.14
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,221,975,187.66	-3,221,975,187.66
2013 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	14,410,826,088.57	1,937,089.76	-4,798,886,445.85	9,613,876,732.48
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,491,725,775.52	-3,491,725,775.52
2014 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	14,410,826,088.57	1,937,089.76	-8,290,612,221.37	6,122,150,956.96

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН	800,953,300.00	761,203,146.48	39,750,153.52	95.0
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	800,953,300.00	761,203,146.48	39,750,153.52	95.0
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	770,953,300.00	732,294,906.48	38,658,393.52	95.0
Бараа, үйлчилгээний зардал	607,903,300.00	577,727,706.48	30,175,593.52	0.0
Ажиллагчидтай холбогдсон зардал	450,190,700.00	425,234,668.67	24,956,031.33	94.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,577,300.00	383,040,282.42	22,537,017.58	94.4
Үндсэн цалин	380,167,300.00	359,283,182.42	20,884,117.58	94.5
Унаа хоолны хөнгөлөлт	25,410,000.00	23,757,100.00	1,652,900.00	93.5
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	44,613,400.0	42,194,386.25	2,419,013.75	94.6
Тэтгэврийн даатгал /7%/	28,390,400.00	26,850,973.15	1,539,426.85	94.6
Тэтгэмжийн даатгал /05%/	3,244,600.00	3,068,682.62	175,917.38	94.6
ҮОМШ өвчний даатгал /1%/	4,055,700.00	3,835,853.28	219,846.72	94.6
Ажилгүйдлийн даатгал /0.5%/	811,100.00	767,170.65	43,929.35	94.6
Байгууллага төлөх ЭМД-ийн хураамж /2%/	8,111,600.00	7,671,706.55	439,893.45	94.6
Бараа, үйлчилгээний бусад зардал	157,712,600.00	152,493,037.81	5,219,562.19	96.7
Бичиг хэрэг	3,543,900.00	2,123,799.00	1,420,101.00	59.9
Тээвэр шатахуун	26,261,100.00	26,180,580.00	80,520.00	99.7
Шуудан холбоо	15,141,100.00	14,892,434.01	248,665.99	98.4
Дотоод томилолт	8,246,800.00	5,058,783.80	3,188,016.20	61.3
Гадаад томилолт /арга хэмжээ/	56,895,700.00	57,872,620.00	-976,920.00	101.7
Ном, хэвлэл авах	1,312,000.00	1,023,300.00	288,700.00	78.0
Төлбөр хураамж болон бусад зардал	7,000,000.00	6,029,521.00	970,479.00	86.1
Байрны түрээсийн зардал	39,312,000.00	39,312,000.00	0.00	100.0
Татаас ба урсгал шилжүүлэг	163,050,000.00	154,567,200.00	8,482,800.00	94.8
Өрх гэрт олгох шилжүүлэг	161,550,000.00	153,067,200.00	8,482,800.00	94.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил	161,550,000.00	153,067,200.00	8,482,800.00	94.7
Гадаад шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
ОУ-ын гишүүний татвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
Хөрөнгө оруулалт	30,000,000.00	28,908,240.00	1,091,760.00	96.4
Тоног төхөөрөмж	30,000,000.00	28,908,240.00	1,091,760.00	96.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	800,953,300.00	761,203,146.48	39,750,153.52	95.4
Төсвөөс санхүүжих	800,953,300.0	761,203,146.48		
Мөнгөн хөрөнгийн эхний үйлдэгдэл		3,679.50		0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,500.30		0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		
АЖИЛЛАГСАД БҮГД	35	35		
Удирдах ажилтан	4	4		
Гүйцэтгэх ажилтан	31	31		

